



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/556

Улаанбаатар хот

「Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион  
байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 7 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 176 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг нэгдүгээр, Агентлагийн зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Агентлагийн зохион байгуулалтын бүтэц шинээр батлагдсантай холбогдуулан энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан хөтөлбөрт тусгагдсан стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд агентлагийн болон түүний харьяа орон нутгийн хэлтсүүдийн бүтэц, чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Бямбасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Хөтөлбөр батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/340 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН

141202180

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 11 сарын 30 өдрийн 1/ тушаалын  
нэгдүгээр хавсралт 556

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (цаашид “ЭМДЕГ” гэх)-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын болон холбогдох бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийн хүрээнд ЭМДЕГ-ын тэргүүлэх чиглэл, эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтыг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэдгээрийн чиг үүргийг тогтооход оршино.

#### 1.1. Хөтөлбөр боловсруулах болсон үндэслэл:

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн ерөнхий загвар”, Засгийн газрын 2013 оны 143 дугаар тогтоолоор сайшаасан “Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги”, Засгийн газрын “Агентлаг байгуулах тухай” 2017 оны 344 дүгээр тогтоолыг тус тус үндэслэл болгов.

#### 1.2. Хууль тогтоомжийн орчин:

Хөтөлбөрийг доор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль;
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Бусад хууль тогтоомж.

### 1.3. Арга зүй:

Хөтөлбөрийг боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, эрүүл мэндийн даатгалын урт хугацааны стратеги, Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг 2017-2021 онд хөгжүүлэх “Дунд хугацааны стратеги төлөвлөгөө”, эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийн бодлого, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, эрүүл мэндийн даатгалын салбарт хуримтлагдсан туршлага, даатгалын хэтийн төлөв, хандлага, байгууллагын үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө зэрэгт тулгуурласан болно.

### 1.4. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь:

ЭМДЕГ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд эрүүл мэндийн даатгалын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, даатгалын үйлчилгээг тасралтгүй, шуурхай зохион байгуулах үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

ЭМДЕГ нь Монгол улсын иргэн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас худалдан авах үүрэг хариуцлагыг даатгуулагчийн өмнө хүлээнэ.

### 1.5. ЭМДЕГ-ын стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч, үйлчлүүлэгч:

**Зураг 1. Стратегийн удирдлага, үндсэн хэрэглэгчийн загвар**



## **Хоёр. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги**

### **2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар:**

ЭМДЕГ-ын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалан тэдний эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээг худалдан авах арга хэмжээг мэргэжлийн өндөр түвшинд хангаж, эрүүл мэндийн даатгалын асуудлаар бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.

### **2.2. Тэргүүлэх чиглэл:**

2.2.1. даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ худалдан авдаг, үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;

2.2.2. даатгуулагчийн эрхийг дээдэлж, даатгуулагчийг санхүүгийн эрсдлээс хамгаалах;

2.2.3. байгууллагын дотоод гадаад харилцааг өргөжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалан даатгуулагч төвтэй, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;

2.2.4. эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн цахим сүлжээг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, системийн аюулгүй, найдвартай байдлыг хангах .

### **2.3. Эрхэм зорилго:**

Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино.

### **2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт:**

ЭМДЕГ нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн доор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.1. Агентлагийн хүний нөөцийн бодлогын болон үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;

2.4.2. Эрүүл мэндийн даатгалын талаарх бодлогын хэрэгжилтийг хангах, зохицуулалт хийх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.4.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг чанарт үндэслэн сонгох болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах;

2.4.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд холбогдох стандарт, эмнэлзүйн зааврын дагуу хяналт тавих;

2.4.5. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, төлбөр тооцоо гүйцэтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, гүйцэтгэлийг тайлагнах;

2.4.6. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дотоод аудит, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ;

2.4.7. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, эрүүл мэндийн даатгалын үндэсний мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх;

2.4.8. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх талаар иргэд, даатгуулагчаас ирүүлсэн хүсэлт, гомдлыг шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах

2.5. Үйл ажиллагааны гол зорилт:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 2.4.1 дүгээр зорилтын хүрээнд:

а) Эрүүл мэндийн даатгалын байгууллагын эрхэм зорилго, стратеги зорилтуудыг хангахуйц хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, хүний нөөцөөр хангах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хүний нөөцийг чадавхжуулах;

б) Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайн түншлэлийн харилцааг хөгжүүлэх замаар байгууллагын хөгжил, тогтвортой байдлыг хангах;

в) Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг хэрэгжүүлж, ил тодоор тайлагнах.

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2.4.2 дугаар зорилтын хүрээнд:

а) Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар судалгаа хийж, санал боловсруулах, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

б) Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журам, дүрэм, аргачлал, зааврын санал боловсруулах, төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

в) Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, үйл ажиллагааны зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, төсөөллийн саналыг хэтийн тооцоо, статистик мэдээлэл, судалгаанд тулгуурлан боловсруулах;

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 2.4.3 дугаар зорилтын хүрээнд:

а) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийг чанарт үндэслэн сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах, сонгон шалгаруулах журам, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох;

б) Сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай даатгалын гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх, гэрээний удирдлагыг боловсронгуй болгох, гэрээний шалгуур үзүүлэлт, техникийн тодорхойлолтыг боловсронгуй болгох;

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 2.4.4 дүгээр зорилтын хүрээнд:

а) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэлд хяналт тавих нотлох үйл ажиллагааг цахимаар болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх,

б) Нэхэмжлэлийн хяналтад суурилсан нарийвчилсан хяналтыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага дээр хийх, энэ чиглэлээр холбогдох албадтай хамтран ажиллах;

в) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний худалдан авалтад хяналт хийж, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 2.4.5 дугаар зорилтын хүрээнд:

а) Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, өр авлагыг барагдуулах, сангийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн болон үйл ажиллагааны урсгал зардлыг хуулийн хугацаанд олгох, төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх;

б) Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, бүртгэлийн журам, заавар, аргачлалын санал боловсруулах, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн сангийн гүйцэтгэлийг тайлагнах, мэдээлэх;

в) Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэд, оюутан, сурагчид зэрэг зорилтот бүлгийн хүмүүсийг даатгалд бүрэн хамруулах чиглэлээр баг, хорооны Засаг дарга, их, дээд сургуулийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захиргаатай хамтран ажиллах.

2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 2.4.6 дугаар зорилтын хүрээнд:

а) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, эмнэл зүйд ижил мэргэжилтний үнэлгээг зохион байгуулах замаар хөндлөнгийн хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

б) Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дотоод үйл ажиллагааг үнэлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх зэргээр байгууллагын дотоод нэгжүүдийн үйл ажиллагаа, ажлын уялдаа холбоо, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулахад чиглэсэн зөвлөмжөөр хангах.

в) Даатгалын тусламж, үйлчилгээний багцыг үр дүнтэй удирдаж, сангийн орлого, зарлагын тэнцвэрийг хадгалах, даатгалын үйлчилгээний үр ашгийг сайжруулах чиглэлээр судалгаа шинжилгээ хийх.

#### 2.5.7. Үйл ажиллагааны стратегийн 2.4.7 дугаар зорилтын хүрээнд:

а) Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, даатгуулагч, эмнэлэг, эмийн сан, даатгалын байгууллага болон шаардлагатай бусад төрийн байгууллагыг холбосон үндэсний мэдээллийн цахим системийг бий болгож, системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах;

б) Даатгуулагч, эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талуудыг шаардлагатай мэдээллээр хангах, технологийн боломжийг бүрдүүлэх;

в) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тавих нэхэмжлэлийн болон чанарын хяналтыг цахимаар хийх боломжийг бүрдүүлэх.

#### 2.5.8. Үйл ажиллагааны стратегийн 2.4.8 дугаар зорилтын хүрээнд:


а) Нийгмийн маркетингийн үр дүнтэй механизмыг хэрэгжүүлэх, даатгуулагчид үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тариф, хамтын төлбөрийн мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийг иргэд олон нийтэд хүртээмжтэй байдлаар цахимаар болон бусад зохистой сувгаар мэдээлэх;

б) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, төлбөр болон бусад асуудлаар даатгуулагч иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах.

#### 2.6. Үйл ажиллагааны стратегийн загвар:

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн загварыг доор дурдснаар тодорхойлж байна.

**Зураг 2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн загвар**



## **Гурав. Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг**

### **3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим:**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг бүрдүүлэхдээ доор дурдсан зарчим баримтална. Үүнд:

**3.1.1. Уялдаатай байх:** Агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байна.

**3.1.2. Эрх мэдлийн ялгаа, зааг тодорхой итгэл хүлээхүйц байх:** Бүтцийн нэгжүүд тэдгээрийн албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаалтан ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, албан тушаалтны ажлын уялдаа, мэргэшлийн чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ сайдын эрхлэх ажлын болон бусад агентлагийн зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх

**3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх:** Зохион байгуулалтын нэгжийн нэр нь товч, үйл ажиллагааны стратегийг илэрхийлсэн оновчтой байх)

**3.1.4. Бүтцийн хувьд энгийн, удирдлагын цөөн шат дамжлагатай байх:** Агентлагийн даргаас доод нэгж хүртэл аль болох цөөн шат дамжлагатай байх)

**3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох:** Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар хялбар, шуурхай удирдах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэж, бүтцийн ерөнхий тогтолцоог бүрдүүлсэн байх )

**3.1.6. Хангалттай чадавх, бодитой үйл ажиллагаатай байх:** Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх

**3.1.7. Улс төржихгүй байх:** Төрийн албан хаагч нь улс төрийн болон шашны нөлөөнд автахгүй, төвийг сахисан мэргэжлийн ёс зүйтэй байх.

### **3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар:**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны байдлыг доор дурдсанаар тодорхойлж байна.


**Зураг 3. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар**



**3.3. Зохион байгуулалтын бүтэц:**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус агентлагийн зохион байгуулалтын бүтцийн ерөнхий загварыг дараах байдлаар тодорхойлж байна.

**Зураг 4. Агентлагийн үүрэг, функцийн ерөнхий загвар**



**3.3.1. Эрүүл мэндийн даатгалын төрийн захиргааны үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг:**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.1 дүгээр зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- байгууллагын жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах түүний биелэлтийг хангуулахад чиглэсэн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- байгууллагын хүнд суртал, авлига, ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл, бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;
- агентлагийн даргын зөвлөлийн болон шуурхай хурал, албан хаагчдын сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах, гарсан шийдвэр, өгөгдсөн үүрэг даалгаврыг албажуулж, хэрэгжилтийг хангуулах;
- хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг нэгтгэх, холбогдох байгууллагад хугацаанд нь тайлагнах, удирдлагыг мэдээллээр хангах;

- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, судалгаа, мэдээ, тайланг нэгтгэн хүргүүлэх, албан тушаалтны хөрөнгө, орлогын болон урьдчилсан мэдүүлгийг гаргуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх, бүртгэх, хадгалах;
- ажилтны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын дарга болон нэгжийн даргаар батлуулах ажлыг арга зүйн болон зохион байгуулалтын удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;
- байгууллагын гадаад, харилцаа, хамтын ажиллагааг хариуцах, хэрэгжүүлэх, тайлагнах;
- байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг эрхлэх, арга зүйн дэмжлэг, удирдлагаар хангах, хяналт тавих;
- агентлагийн албан байрны ашиглалт, засвар, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалт, хэвийн үйл ажиллагааг хангаж, автомашины бэлэн байдал, үйлчилгээ, техникийн аюулгүй байдлыг хангах;
- байгууллагын зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, салбарын тасралтгүй, хэвийн жигд үйл ажиллагааг хангах;
- байгууллага, орон нутгийн нэгжүүдийн хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах, сайжруулах, хүний нөөцийн нийлүүлэлт, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, албан тушаал дэвших, бууруулах асуудлыг шийдвэрлүүлэх
- төрийн албан хаагчдын хувийн хэрэг, тоо бүртгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтлөх, хадгалах, хамгаалах, баяжуулах, хүний нөөцийн судалгаа, тайланг нэгтгэн, холбогдох байгууллагад хүргүүлэх;
- төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны болон бусад зөвшөөрөгдсөн нэмэгдэл хөлсийг ахиулах, нэмэгдүүлэх, хасах, хүчингүй болгох болон шагнаж, урамшуулах талаар санал гаргах, хэрэгжүүлэх;
- эрүүл мэндийн даатгалын Улсын байцаагчийн эрх олгох шалгалтыг зохион байгуулах, бүртгэх, эрхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх санал гаргах, үнэмлэх, тэмдэг олгох, хураах;
- байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон захиргаа, хүний нөөцтэй холбоотой дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;
- байгууллагын ажилтны мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийж, сургалтад хамруулах, ажилтны ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгэм, эрүүл мэндийн баталгааг хангах талаар санал, хүсэлтийг судлах, санал гаргах, хэрэгжилтийг хангах.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь агентлагийн үйл ажиллагааг зохион байгуулах, ажлын байранд сургалт явуулж, цомхон чадварлаг хүний нөөц бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр агентлагийн тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэгдэнэ.

Уг нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга, дэд дарга нар болон төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажиллагчид байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь харьяалах яам, сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад байгууллага, албан тушаалтан байна.

3.3.2. Эрүүл мэндийн даатгалын бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.2 дугаар зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцад хамаарах тусламж, үйлчилгээний нэр төрөл, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, багцад зохицуулалт хийх болон эдгээртэй холбоотой журам, заавар, аргачлал боловсруулах;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хамтын төлбөрийн хэмжээг тогтоох, өөрчлөх болон хамтын төлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, заавар боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэг (DRG)-т үнэлгээ хийж өөрчлөх болон сайжруулах талаар санал боловсруулах;
- эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн багцыг тодорхойлох;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн аргыг тодорхойлох;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналтыг хэрэгжүүлэхэд ашиглах тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг холбогдох мэдээлэлд үндэслэн тодорхойлох, тэдгээрийг шинэчлэх, хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлал боловсруулах;
- нэхэмжлэлийн цахим болон нарийвчилсан хяналтын шалгуурыг олон улсын эмнэлзүйн удирдамж ашиглан боловсруулж, тогтоох, шинэчлэх;
- ижил мэргэжилтний үзлэг, чанарын үнэлгээний журам, аргачлалыг боловсруулах, шинэчлэх;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад шинээр нэмэгдэх тусламж, үйлчилгээнд өртөг, үр ашгийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад үнэлгээ хийж
- ЭМД-ын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний удирдамжийг үндэслэн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ, хөнгөлөлттэй эм худалдан авах өртгийн тооцоолол хийж тариф тодорхойлох;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үнийн хэлцлийг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хийж тохиролцох;
- эмийн үнийн дээд хязгаар болон даатгалын сангаас санхүүжүүлэх хэмжээг тогтоох;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын эрэлтийн прогнозд үндэслэн ЭМД-ын санд үзүүлэх санхүүгийн дунд болон урт хугацааны нөлөөллийн тооцооллыг боловсруулах;
- ЭМД-ын сангийн жилийн болон дунд хугацааны орлого, зарлагын төлөвлөгөө боловсруулах, батлагдсан төсвийн хуваарилалт, зохицуулалт хийх;
- ЭМД-ын сангийн орлого, зарлагын харьцаанд дүн шинжилгээ хийж даатгуулагч тус бүрээр төлөх даатгалын шимтгэлийн боломжит хувилбарыг тодорхойлох;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад үнэлгээ хийж тусламж, үйлчилгээ үзүүлэгчдээс үзүүлж байгаа сөрөг үйлдэлд хариу арга хэмжээ авах санал боловсруулах.

- холбогдох мэдээлэлд үндэслэн тусламж, үйлчилгээний эрэлтийн богино, дунд, урт хугацааны прогноз хийж тухайн жилд худалдан авах тусламж, үйлчилгээний боломжит тоо хэмжээ, зохистой харьцааг тодорхойлох;
- хүн амын эрүүл мэндийн даатгалд хамрагдалт, ЭМД-ын сангийн орлого ба зарлага, худалдан авсан тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, чанарын үзүүлэлт зэрэг мэдээллийг цуглуулах, нэгтгэх, мэдээлэлд боловсруулалт, дүн шинжилгээ хийж цаашдын хандлагыг тодорхойлох, мэдээллийг түгээх;
- ЭМД-аар худалдан авсан тусламж үйлчилгээний талаарх холбогдох судалгааг (нөлөөллийн, хандлагын, сэтгэл ханамжийн, хүртээмжийн гэх мэт) холбогдох газар, хэлтэстэй хамтран хийх.

Энэ нэгжийн удирдлага, ажилтнууд нь бусад зохион байгуулалтын нэгжийн удирдлага, ажилтнуудтай багаар хамтран ажиллана. Уг нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгж, тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагч иргэд байна.

3.3.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах, эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулах үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг

Энэхүү нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.3 дугаар зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч этгээдийг сонгон шалгаруулах журам, шалгуур үзүүлэлтийг боловсруулах;
- сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг мэдээлэх;
- сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн баазыг бүрдүүлэх;
- тухайн жилд худалдан авах тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг холбогдох газар, хэлтэстэй хамтран тодорхойлох;
- эрүүл мэндийн байгууллагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх;
- эрүүл мэндийн даатгалын гэрээг тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зарчим, арга зүйтэй уялдуулах зэргээр гэрээний менежментийг сайжруулах;
- худалдан авах гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээрийн техникийн тодорхойлолтыг холбогдох газар, хэлтэстэй хамтран тодорхойлох
- эрүүл мэндийн даатгалын байгууллагыг төлөөлж гэрээ болон хууль, эрх зүйн холбогдолтой аливаа үйл ажиллагаанд оролцох, байгууллагын газар, хэлтэс албадад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

Энэ нэгжийн удирдлага, ажилтнууд нь бусад зохион байгуулалтын нэгжийн удирдлага, ажилтнуудтай багаар хамтран ажиллана. Уг нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, агентлагийн дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

3.3.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.4 дүгээр зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийн дагуу нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэх;
- нэхэмжлэлийн цахим болон нарийвчилсан хяналтыг олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурын дагуу гүйцэтгэх;
- нэхэмжлэлийн хяналтын үр дүнд суурилан эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хийсэн гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу газар дээр нь очиж хяналт-үнэлгээ хийж дүгнэлтийг худалдан авалт гэрээлэлтийн газарт шилжүүлэх;

Энэ нэгжийн удирдлага, ажилтнууд нь бусад зохион байгуулалтын нэгжийн удирдлага, ажилтнуудтай багаар хамтран ажиллана. Уг нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, агентлагийн дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

3.3.5. Санхүү бүртгэлийн үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.5 дугаар зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- ЭМД-ын сангийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, сарын мэдээг хуульд заасан хугацаа, стандарт, журмын дагуу тайлагнах;
- ЭМД-ын сангийн төсвийн төлөвлөгөөний дагуу шимтгэлийн орлого бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;
- батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих,
- төлбөр тооцоог хянаж гэрээнд заасан хугацаанд шуурхай гүйцэтгэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
- өр төлбөр, авлагыг барагдуулах арга хэмжээг зохион байгуулах;
- ЭМД-ын сангийн орлого, зарлага болон бусад мэдээллийг холбогдох газар, хэлтэстэй хамтран боловсруулах, тайлагнах ажлыг зохион байгуулах
- малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэд, оюутан, сурагчид зэрэг зорилтот бүлгийн хүмүүсийг ЭМД-д бүрэн хамруулах чиглэлээр баг, хорооны Засаг дарга, их, дээд сургуулийн болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захиргаатай хамтран ажиллах.

Уг нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгж, тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагч иргэд байна.

Энэ нэгжийн гол түнш нь эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж, улсын бүртгэлийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага тус тус байна.

3.3.6. Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.6 дугаар зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, бодлого төлөвлөлтийн нэгжид ЭМД-ын тогтолцоог сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмжөөр хангах;
- байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
- байгууллагын удирдлагыг мэдээлэл, зөвлөмжөөр хангах
- дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулах

3.3.7. Олон нийттэй харилцах үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.7 дугаар зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- ЭМД-ын талаар гарсан төрийн болон салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэйгээр хүргэх, сурталчлах ажлыг шуурхай зохион байгуулах, даатгуулагч, эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- олон нийтэд хүргэх мэдээллийн хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг тодорхойлж, орчин үеийн дэвшилтэд технологийг ашиглан мэдээллийг хүргэх;
- салбарын хэмжээнд гарсан бодлогын баримт бичгийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлтийн тухай мэдээллийг харьяа байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулах, мэдээлэл солилцох, эргэх холбоотой ажиллах;
- салбарын цаг үеийн мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор радио, телевиз, сонин хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай байгуулсан сурталчилгааны гэрээний хэрэгжилтийг хангах, тайлагнах, хяналт тавих;
- мэдээллийн хэрэгслээр салбарын үйл ажиллагаатай холбогдолтой гарч байгаа мэдээлэл бүртэй нэг бүрчлэн танилцаж, удирдлага, холбогдох нэгжийг мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аливаа ташаа мэдээллийг залруулах ажлыг шуурхай зохион байгуулах;
- салбарын үйлчилгээний маркетингийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;
- сурталчилгааны зориулалттай ном товхимол, гарын авлага, зурагт хуудасны эх бэлтгэлийг хийх, хэвлүүлэх, түгээх;
- сурталчилгааны шинэ хэв маягийг эрэлхийлэх, хэрэгжүүлэх санал боловсруулах, хэрэгжилтийг хангах;
- иргэд, даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалын сан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой санал, өргөдөл

гомдлыг хүлээн авах, хариу өгөх, бүртгэх, шийдвэрлэх, тайлагнах ажлыг хариуцан зохион байгуулах;

- олон нийттэй харилцах менежментийг нэвтрүүлэх, шууд утас ажиллуулах, цахим хуудсаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх;
- эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын мэдээллийг мэдээллийн хэрэгсэл, сургалт сурталчилгааны бусад хэлбэрээр дамжуулан хүргэх,
- даатгуулагчаас тусламж, үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн судалгааг бусад нэгжтэй хамтран зохион байгуулж үр дүнг холбогдох байгууллагуудад болон олон нийтэд ил тод мэдээлэх;

Уг нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь агентлагийн дарга, дэд дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгж, тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, даатгуулагч, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага байна.


3.3.7.Мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын нэгжийн үндсэн чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2.4.7 дугаар зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- ЭМД-ын үйлчилгээнд мэдээллийн технологийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах,
- ЭМД-ын цахим системийг өгөгдсөн даалгаврын дагуу боловсруулж, хөгжүүлэлт хийх
- ЭМД-ын цахим системийг холбогдох бусад системүүдтэй холбох, мэдээлэл солилцох боломжоор хангахад чиглэсэн системийн өргөтгөл, сайжруулалт хийх;
- ЭМД-ын мэдээллийн системийн нууцлал, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;
- ЭМД-ын байгууллагын дотоод үйл ажиллагааны технологийн нэгдсэн системийг сайжруулах, ашиглалтын найдвартай байдлыг хангах, техник, програм хангамжийн шинэчлэл, боловсруулалт, нэвтрүүлэлт, өгөгдөл мэдээллийг цуглуулах, дамжуулах.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын байгууллага, ажилтнууд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, мэдээллийг цахим орчинд солилцох төрийн бусад байгууллага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь даатгуулагч, иргэд, аж ахуйн нэгж байна.

АГЕНТЛАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГТЫН БҮТЭЦ



2020 оны 11 сарын 30-ны өдрийн 1586 хоёрдугаар хэвсрэлт

Эрүүл мэндийн сайдын 1586/2020-нөмөр

Түшээл